


БАТЛАВ:

“ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ Ч.БАТ-ЭРДЭНЭ



БАТЛАВ:

“МАЕСТОЗО” ПРОДАКШН ХХК-ИЙН
ЗАХИРАЛ В.БАТТӨР



АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2016.07.25

Дугаар

Улаанбаатар хот

2016 07 25 035

Нэг талаас “Эрүүл мэндийн хөгжлийн төв ” /цаашид захиалагч гэх/ түүнийг төлөөлж Захиргаа, аж ахуйн албаны дарга Л.Оюунчимэг, нөгөө талаас Монгол Улсын аж ахуйн нэгж болох 9011624017 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ, 6096425 тоот регистрийн дугаартай “Маестозо продакшн” ХХК /цаашид “зохион байгуулагч “Компани” гэх/ түүнийг төлөөлж захирал В.Баттөр /цаашид гүйцэтгэгч гэх/ нар нь Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 20 жилийн ойн хүндэтгэлийн арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдаж байгаа үйл ажиллагаа, баярын арга хэмжээнд хамтран ажиллах эрх зүйн харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 20 жилийн ойн хүндэтгэлийн арга хэмжээг боловсруулсан хөтөлбөрийн хүрээнд баярын арга хэмжээг зохион байгуулж, энэхүү гэрээний хавсралтын дагуу урлагийн тоглолт болон хавсралтад заагдсан арга хэмжээг зохион байгуулна.

Хоёр. Гэрээний хугацаа

- 2.1. Гэрээ байгуулсан өдөр: 2016 оны 07 дугаар сарын 25-ны өдөр
- 2.2. Гэрээний дуусгавар болох хугацаа: “Талууд гэрээнд заасан үүргээ бүрэн гүйцэтгэж дууссан” үед буюу 2016 оны 09-р сарын 16-ны өдөр байна.

Гурав. Захиалагч талын эрх, үүрэг

- 3.1 Гүйцэтгэгчийг шаардлагатай мэдээллээр хангана.
- 3.2 Төлбөр тооцоог гэрээнд заагдсан хугацаанд хийж гүйцэтгэнэ.
- 3.3 Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 20 жилийн ойн хүндэтгэлийн арга хэмжээг боловсруулсан хөтөлбөрийн хүрээнд хөтлөн зохион байгуулах ба арга хэмжээнд хамтлаг, дуучидыг бүрэн ирүүлэх үүрэг хүлээнэ.
- 3.4 Ажлын явцад хяналт тавих, чанарыг шалгаж, санал, заавар, дүгнэлт өгөх;
- 3.5 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Зохион байгуулагчаас шаардах.

Дөрөв. Зохион байгуулагчийн эрх, үүрэг

- 4.1 Гэрээнд заагдсан хугацаа буюу 2016 оны 9 -р сарын 15-ны өдөр Дуурь бүжгийн эрдмийн театрын баярын хүндэтгэлийн хурал, урлагийн тоглолт болон оройн хүндэтгэлийн хүлээн авалтын арга хэмжээнд бэлэн байна.

4.2 Гэрээнд заасан хугацаа, нөхцлөөр, өөрийн материал, хэрэгслийг ашиглан мэргэжлийн өндөр түвшинд, алдаа дутагдал, доголдолгүй хийж гүйцэтгэнэ. Захиалагчаас хамтын ажиллагаатай холбогдуулан санал, заавар, дүгнэлт өгвөл хүлээн авах, тусгах, биелүүлэх;

4.3. Хамтын ажиллагааны үеэр захиалагчаас авсан баримт, материал, тоног төхөөрөмж (хэрэв байгаа бол)-ийг ажлыг хүлээлцэх үед захиалагчид бүрэн бүтэн буцаан өгөх;

4.6. Гэрээгээр хүлээсэн бусад үүргээ биелүүлэх

4.7 Гэрээний 3 дугаар зүйлд заасан журмаар захиалагчаас төлбөрийг шаардаж авах;

4.8 Гэрээний хугацаанд захиалагч талаас шаардлагатай мэдээ мэдээллийг авах,

4.9 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг захиалагч талаас шаардах.

4.10 Энэхүү хүндэтгэлийн арга хэмжээг батлагдсан ЕРӨНХИЙ ХӨТӨЛБӨР-ийн дагуу зохион байгуулна.

Тав. Гэрээний төлбөрийн нөхцөл

5.1. Хамтын ажиллагааны төлбөр нь: 6,700.000 төгрөг байна.

5.2. Гэрээт ажлын хөлсийг гэрээ байгуулагдаж, бэлтгэл ажлыг эхэлснээс хойш ажлын 3 хоногт багтаан урьдчилгаа 60% хувь буюу 4.020.000 төгрөгийг гүйцэтгэгч байгууллагын данс Голомт банк 1415109220 тоот төгрөгийн дансанд, үлдэгдэл 40%-ийг гэрээ дүгнэсэн тэмдэглэлийг үндэслэн тус тус шилжүүлнэ.

Зургаа. Бусад зүйл

6.1 Харилцагч талууд гэрээг баталж, гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.


6.2 Гэрээт ажлыг гүйцэтгэхэд хоёр тал харилцан итгэлцэл, хамтын ажиллагааны найдвартай байдлыг ханган ажиллана.

6.3 Гэрээг гурав хувь үйлдэж талууд хадгалсан нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.


6.4 Маргаантай асуудлыг талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэх ба шийдвэрлэх боломжгүйд хүрвэл Монгол улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Эрүүл мэндийн хөгжлийн төвийг
төлөөлж: ЗААА-ны дарга

 Л.Оюунчимэг

Гүйцэтгэгчийг төлөөлж:

“Маестозо продакшн”-ны захирал
 Б.Баттөр

